



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 11/127

Баянхутаг сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн А/469 дүгээр захирамж, Аймгийн Онцгой байдлын газрын даргын 2024 оны 37/354 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бие бялдрыг хөгжүүлэх, гамшигтай тэмцэх ур чадварыг дээшлүүлэх, гамшгийн аюулаас нэрвэгсдийг аврах, эрэн хайх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг дадлага олгох зорилготой аймгийн аварга шалгаруулах “Аврагч-2024” тэмцээнд оролцож тэргүүн байр эзэлсэн Соёлын төвийн дарга С.Мөнххэрлэнгийн ажлын үр дүнг үндэслэн сарын үндсэн цалингийн 50 /Тавь/ хувийн урамшуулал олгосугай.

2. Урамшуулал олгохыг Нягтлан бодогч /Х.Энхцэцэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.АМГАЛАНБАТ